



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2024.07.23 № 581

таний -ны № -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
ХЭРЛЭН СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Хэрлэн сумын Монгол ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцс хам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох хам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай

232420610

хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хэрлэн сумын Монгол ардын намын хорооны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хэрлэн сумын Монгол ардын намын хорооны мөрийн хөтөлбөр (8 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Аймгийн сонгуулийн хороонд.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /Ж.ГАНБААТАР/
ХЯНАСАН:
АУДИТИН МЕНЕЖЕР /Д.ОЮУНТУЯА/
БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР /Ц.БИЛЭГСАЙХАН/
АУДИТОР /Ц.ХАТАНБОЛД/

2317440297
СНОА0046 9074082



.. тоотын хавсралт

ХЭРЛЭН СҮМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ ХЭРЛЭН СҮМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ МӨРИЙН
ХӨТӨЛБӨР

АГУУЛГА

НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРД ХҮРГЭХ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН
БОДЛОГО

- 1.1. Орон сууц
- 1.2. Эрүүл мэнд
- 1.3. Боловсрол
- 1.4. Халамж, хөдөлмөр эрхлэлт
- 1.5. Үндэсний бахархал, өв соёл, спорт
- 1.6. Хүүхэд гэр бүлийн хөгжил
- 1.7. Аюулгүй амар тайван байдал

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 2.1. Хөдөө аж ахуй
- 2.2. Аялал жуулчлал
- 2.3. Дэд бүтцийн сүлжээ
 - 2.3.1. Эрчим хүчний төсөл
 - 2.3.2. Авто зам



ГУРАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

ДӨРӨВ. ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРД ХҮРГЭХ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1. Орон сууц

1.1.1. Түрээсийн орон сууц хөтөлбөрийн хүрээнд иргэдэд түрээслээд өмчлөх орон сууцны төслийг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.

1.1.2. Инженерийн дэд бүтэц шийдэгдсэн газарт амины орон сууц барих ажлыг дэмжиж хөнгөлөлттэй зээлийг банк санхүүгийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

1.1.3. Төрийн албан хаагч, залуу гэр бүлд чиглэсэн орон сууцны төслийг хэрэгжүүлж, ипотекийн зээлийн асуудлыг шийдвэрлэхэд банк санхүүгийн байгууллагатай хамтран ажиллана.

1.2. Эрүүл мэнд

1.2.1. Хэрлэн суманд Жишиг өрхийн эмнэлэг барьж ашиглалтад оруулна.

1.2.2. Хүн амыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зорилтот бүлгийн иргэдийг жил бүр “Эрт илрүүлэг” үзлэг шинжилгээнд хамруулна.

1.2.3 Эрүүл мэндийн боловсролыг иргэдэд, хүүхдэд бага наснаас нь эзэмшүүлэх, хэвшүүлэх зорилгын хүрээнд Эрүүл зөв хооллолт, дасгал хөдөлгөөнийг тогтмолжуулах ажлыг зохион байгуулна.

1.2.4. “Элэг бүтэн Монгол”, “Эрүүл шүд- Эрүүл ирээдүй”, “Хавдаргүй Монгол” хөтөлбөрүүдийг орон нутагт үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.2.5. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг сэргээн засах, физик эмчилгээний тоног төхөөрөмж, урьдчилан сэргийлэх оношлуураар хангаж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэн бүрд хүртээмжтэй хүргэнэ.

1.3. Боловсрол

1.3.1. Хэрлэн суманд 120 хүүхдийн яслийн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулан 1-2 хүртэлх насны хүүхдийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ.



1.3.2. Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 160 ортой хүүхдийн дотуур байр, Хэрлэн 4, 5 дугаар сургуулийн 100 ортой хүүхдийн дотуур байрыг шинээр барьж ашиглалтад оруулна.

1.3.3. Хэрлэн сумын Ерөнхий боловсролын Тэмүүжин цогцолбор сургуулийн бага сургуулийн барилгыг буулгаж, шинээр 960 хүүхдийн хичээлийн байр барьж ашиглалтад оруулна.

1.3.4. Хэрлэн сумын Хан Хэнтий цогцолбор сургуулийн урлаг заал, гал тогооны барилгын өргөтгөлийг барьж байгуулна.

1.3.5. Ерөнхий боловсролын Хэрлэн 1 дүгээр сургуулийн автозогсоолыг шинээр барина.

1.3.6. Хүн амын төвлөрөл ихтэй газарт нэгээс доошгүй цэцэрлэгийг шинээр барина.

1.3.7. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрыг засварлан зориулалтын тоног төхөөрөмжөөр хангаж, орчин нөхцөлийг сайжруулна.

1.3.8 ЕБС, СӨББ-ын орчныг бүрэн камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.

1.3.9 Хүүхэд бүрийг ЕБС, СӨББ-д хамруулж, бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэнэ.

1.3.10 Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.

1.3.11 ЕБС, СӨББ-д тусгай хэрэгцээт хүүхдийг тэгш хамруулах боломжоор хангаж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурх, хөгжих орчинг бүрдүүлнэ.

1.3.12. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, ажилтны нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.4. Халамж, хөдөлмөр эрхлэлт

1.4.1. Иргэдийг хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжлээр мэргэжлийн сургалтад хамруулан бүтээмжтэй, зохистой ажлын байрыг



бий болгох замаар, хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ажилтай, орлоготой болгож, ядуурлын түвшинг бууруулна.

1.4.2. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулж, оюуны хөдөлмөрийг дэмжсэн цахим, зайн ажлын байрыг дэмжиж хөгжүүлнэ.

1.4.3. Ахмад настны чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрүүлэх, мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлэх хөгжлийн төвүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулж, “Ахмадаа хүндэтгэе” арга хэмжээг жил бүр зохион байгуулна.

1.4.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийгэмд дасан зохицох, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш хамрагдах, бие даан амьдрах, хөгжих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Хүний хөгжлийн төв”- ийг байгуулна.

1.4.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг бүх төрлийн орон сууц, худалдаа үйлчилгээний байгууллагуудад 100 хувь мөрдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана.

1.4.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.

1.4.7 Ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор Малжуулах төсөл, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Гарааны бизнесийг дэмжих, Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн төсөл хөтөлбөрүүдэд иргэд олон нийтийг хамруулна.

1.5. Үндэсний бахархал, өв соёл, спорт

1.5.1. Залуучуудын сургалт, спорт хөгжлийн төвийг барьж байгуулна.

1.5.2. Иргэд идэвхтэй хөдөлгөөн хийх явган аялал, хөдөлгөөнт дасгал, дугуйн спорт зэрэг нийтийн биеийн тамирын төрлүүдийг дэмжиж, хамрах хүрээг өргөжүүлнэ.

1.5.3. Өсвөрийн шигшээ багийн тамирчдыг бэлтгэх тогтолцоог сайжруулж, мэргэжлийн тамирчдын аймаг, бүс, улсын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.

1.6. Хүүхэд, гэр бүлийн хөгжил



1.6.1. Хүүхэд гэр бүлд үзүүлэх хөгжлийн үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэн, нийт хүүхэд гэр бүлийн 50 хувьд үйлчилгээ үзүүлнэ.

1.6.2. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.6.3 Хүүхэд багачуудыг хөгжүүлэх секц дугуйлан, сургалтыг дэмжиж хамtran ажиллана.

1.7. Аюулгүй амар тайван байдал

1.7.1. Архины хамааралтай иргэдийг сайн дурын болон албадан эмчилгээнд хамруулна.

1.7.2. Архины хамааралтай, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдүүдэд тавих хяналтыг сайжруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр нөлөөллийн ажил, арга хэмжээ зохион байгуулна.

1.7.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Цагдаагийн албан хаагчийг сүүлийн үеийн тоног төхөөрөмж, багажаар хангана.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.1. Хөдөө аж ахуй

2.1.1. Малын гаралтай түүхий эд бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэл эрхлэх загвар хоршоодод дэмжлэг үзүүлнэ.

2.1.2. Мал амьтны гаралтай арьс, шир, ноос ноолуурын таваарлаг чанарыг дээшлүүлэхэд дэмжиж хамtran ажиллана.

2.1.3. Малын тоог чанарт шилжүүлэх, ашиг шимийг нэмэгдүүлэх, эрчимжсэн мал аж ахуйг дэмжих, "Монгол мал-II" арга хэмжээг сумандаа хэрэгжүүлнэ.

2.1.4. Усалгаатай газар тариаланг хөгжүүлэн үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн хэрэгцээг хангаж ажиллана.

2.1.5. "Шинэ хоршоо" хөдөлгөөнийг сумын хэмжээнд өрнүүлж, хоршоолохыг дэмжинэ.



2.1.6. Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир боловсруулах цех байгуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлого баримтална.

2.1.7. Малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх аяныг хэрэгжүүлнэ.

2.1.8. Мал амьтнаас хүнд халдвартадаг халдварт өвчний хяналт, сэргийлэлт, яаралтай хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах ажлыг зохион байгуулна.

2.2. Аялал жуулчлал

2.2.1. “Чингис хаан-Монголын эзэнт гүрэн” соёл амралтын хүрээлэн байгуулж ашиглалтад оруулна.

2.2.2. Баатаруудын гудамж болон Цэнгэлдэх хүрээлэнгийн урд талд амралт, аялал жуулчлалын гудамж байгуулна.

2.2.3. Аялал жуулчлалын гол чиглэлийн авто зам дагуу отоглох цэг, худалдаа үйлчилгээний цэгүүдийг бий болгоно.

2.2.4. Нутгийн иргэдэд түшиглэсэн, нүүдэлчин соёлыг харуулсан аялал жуулчлалыг хөгжүүлэх, чадавхижуулах, бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлнэ.

2.3. Дэд бүтцийн сүлжээ

2.3.1. Эрчим хүчний төсөл

2.3.1.1. Чингис хотод баригдаж байгаа дулааны станцыг ашиглалтад оруулж, дулаан хангамж, инженерийн дэд бүтэц байгуулна.

2.3.1.2. Багануур–Чингис–Чойбалсан 220кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барьж, эрчим хүчний тасалдлыг арилгана.

2.3.1.3. Хэрлэн сумын 2 дугаар багт 2500кВА чадалтай 35/6 кВ-ын дэд станц барина.

2.3.1.4. Хэрлэн сумын шинээр олгогдсон газарт суурьшлын бүс бий болгох зорилгоор цахилгаан дамжуулах шугам татах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.3.1.5. Гэр хорооллын гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах орчныг бүрдүүлнэ.

2.3.2. Автозам



2.3.2.1. Θндөрхаан нисэх онгоцны буудлыг ашиглалтад оруулж, нисэх буудлаас аймгийн төв хүртэл 2.9 км хатуу хучилттай авто зам барина.

2.3.2.2 Хэрлэн сумын 6-р багаас Хэрлэн гол хүртэлх 14,2 км авто зам, Хэрлэн голын 265 у/м төмөрбетон гүүрийг барьж дуусган ашиглалтад оруулна.

2.3.2.3. Хэрлэн сумын Θлзийт тосгон, Цогт-Θндөр багийг А0501 магистрал замтай хатуу хучилттай замаар холбоно.

2.3.3.4. Чингис хотын төвийн эвдрэл бүхий автозамыг бүрэн шинэчилнэ.

2.3.3.5. Чингис хотын төвд явган хүний замын сүлжээг бий болгоно.

2.3.3.6 Гэр хорооллын шороон замыг засварлаж, сайжруулсан шороон зам тавина.

2.3.3.7 Авто замын гарц орц, хурд сааруулагчийг стандартад нийцүүлж, автозамын хэвтээ босоо тэмдэг тэмдэглэгээг шинэчилнэ.

ГУРАВ.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

3.1. Хог хаягдлын цогц менежментийг хэрэгжүүлж эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэн, хот, суурин газрууд хог хаягдлын зориулалтын байгууламжтай болно. Чингис хотод I зэргийн ландфил байгууламж бий болгох

3.2. Хог хаягдал ангилан ялгах цехийг байгуулна.

3.3. Эвдрэлд орсон, бохирдсон газрыг нөхөн сэргээх, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлж, хөрсний үржил шимийг нэмэгдүүлэхэд шинэ дэвшилтэт арга замыг тодорхойлж хэрэгжүүлнэ

3.4. Жил бүр 60 мянган мод тарих замаар хамгаалалтын ойн зурvasыг нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг сааруулж “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангана.

3.5 “Хашаандаа сайхан амьдаръя” хөдөлгөөнийг өргөжүүлж, хашаандаа мод бут, зүлэг, нарийн ногооны хүлэмжний аж ахуй эрхлэх иргэдийг дэмжиж ажиллана.



ДӨРӨВ. ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 4.1. Багш, эмч, төрийн албан хаагчдын ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, ажлын хариуцлага, үр дүнг сайжруулна.
- 4.2. Төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх цахим засаглалын үйлчилгээг иргэн бүрд хүргэх хүртээмжийг нэмэгдүүлэн ажиллана.
- 4.3. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах “Асуудлаас шийдэлд” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.
- 4.4. Хэрлэн суманд камержуулалтын системийг бүрэн нэвтрүүлнэ.

ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО-ККЗ

- 5.1. Гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлэн Хэрлэн сумын 3,4,5 дугаар багийн айл өрхийг инженерийн шугам сүлжээнд холбоно.
- 5.2. Хэрлэн суманд Цэвэр усны эх үүсвэрийн худаг шинээр гаргах, нөөцийн сан байгуулна.
- 5.3. Гэр хороололд “Жишиг гудамж” төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 5.4. Гэр хорооллын ундны усны худгийг инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг шат дараатай зохион байгуулна.
- 5.5. Иргэнд үйлчлэх төвийн барилгыг засварлан, тохижилтын ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 5.6. Чингис хотын төвд тодорхой цэгүүдэд мэдээлэл сурталчилгааны ЛЕД самбар бий болгоно.
- 5.7. Гэр хорооллын дунд болон орон сууцнуудын дунд стандартад нийцсэн тоглоомын талбайг байгуулна.
- 5.8. Нийтийн тээврийн маршрутыг шинэчилж, автобусны тоог нэмэгдүүлнэ.
- 5.9. Өндөрхаан тохижилт орон нутгийн төсөвт үйлчилгээний газрын тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж, хотын тохижилтыг сайжруулна.

